НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 16 өдөр Дугаар А/1215 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2 дахь заалт, 45.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Улс, нийслэлийн төсөв болон бусад эх үүсвэрээр нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны дүгнэлт, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж, шийдвэрийг үндэслэн холбогдох гэрээг батлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т даалгасугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээг захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй байгуулахыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар захиалагчийн хяналт тавих эрх шилжүүлсэн байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад, гэрээний бүрдлийг хянахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын тасаг (Б.Дөлгөөн)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захиалагчийн хяналтын байгууллагаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын тасаг (Б.Дөлгөөн)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т тус тус даалгасугай.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнд үүрэг болгосугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан "Эрх шилжүүлэх тухай" Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1110205369